



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 12 сарын 13 өдөр

Дугаар А/639

Хэрлэн сум

“Улсын аварга тогооч шалгаруулах”
тэмцээнд хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь хэсэг, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны “Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” 06 дугаар тогтоол, 18 дугаар хуралдааны “Аймгийн 2023 оны төсөвт өөрчлөлт оруулах тухай” 2 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Хүнсний хувьсгал” үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хүрээнд “Улсын аварга тогооч шалгаруулах” тэмцээнд дэмжлэг үзүүлэхэд 4,800,000 (дөрвөн сая найман зуун мянган) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай, шаардагдах зардлын тооцоог хавсралтаар баталсугай.

2. Шаардагдах хөрөнгийг Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс (С.Нямдаваа)-т, хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ж.Гантулга)-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ



Аймгийн Засаг даргын 2023
оны 12 дугаар сарын 13-ны
дугаар захирамжийн хавсралт

Зардлын тооцоо

Д/д	Зардлын нэр	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Бүгд үнэ
1	Үйл ажиллагааны зардал	2 хоног			3.690.000
2	Шатахуун /түлш/	литр	252	4400	1.110.000
	Нийт				4.800.000